



ХАЛДЛАГАД ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ БАГ

Нууц үгийн тухай

Нууц үг бол цахим гэмт хэргээс хамгаалах, урьдчилан сэргийлэх хамгийн эхний алхам юм. Бүртгэлтэй аккаунтууд хоорондоо ялгаатай, сайн нууц үгтэй байх нь өнөөгийн нөхцөлд зайлшгүй шаардлага болсон бөгөөд тэдгээрийг байнга сольж занших нь зүйтэй. Иймд дараах алхмуудыг гүйцэтгэснээр та сайн нууц үг үүсгэж, түүний аюулгүй байдлыг хангах боломжтой.

1 Аккаунт бүрдээ ялгаатай нууц үг өгөх

Онлайн аккаунтууддаа нэг ижил нууц үг өгөх нь гэр, машин, ажлын газрын хаалгаа нэг түлхүүрээр нээсэнтэй агаар нэг. Мэдээж гэмт хэрэгтэн аль нэг рүү нь л нэвтэрч чадвал таны бүх зүйлд хүрч чадахаар болно гэсэн үг. Ялимгүй төвөгтэй ч илүү аюулгүй тул нууц үгүүдээ яг одоо ялгаатай болгож эхлээрэй.

2 Нууц үгээ амар дөт хүрч, харагдахааргүй газар хадгалах

Нууц үгээ бичиж аваад хадгалах нь муугүй санаа ч цэвэр текстээр, харагдахаар газар, компьютерын цонхон дээр ил хадгалахаас зайлхийгээрэй.

3 Тоо, үсэг, тэмдэгт оролцсон урт хэмжээтэй нууц үг ашиглах

Нууц үг урт байх тусам тааж мэдэхэд хүнд болдог. Том, жижиг үсэг, тоо, тэмдэг оролцуулсан урт / 8 тэмдэгт буюу түүнээс дээш/ нууц үгийг тааж, тайлахад хэцүү байдаг. Мөн '123456' 'password' эсвэл утасны дугаар гэх мэт нийтэд ил мэдээлэл нууц үгээрээ сонгохгүй байхыг зөвлөж байна.

4 Зөвхөн өөрийн мэддэг хэлцийг ашиглах

Өөрийн мэддэг хэлцийг ашиглаад түүнийгээ тодорхой нэг цахим хуудастай холбоотойгоор санах нь сайн нууц үг бүтээх нэгэн санаа юм. Жишээ нь цахим хуудсанд та дараах байдлаар нууц үг бүтээж болно. Болд, Цэцэг хоёр цахим шуудангаар онигоо илгээсэн. Нууц үг: BTsKhE0I гэвэл том жижиг үсэгтэй, тоо оролцсон нууц үг болж байна. Энэ маягаар бусад хаягууд дээрээ ялгаатай нууц үг зохиох боломжтой.

5 Нууц үг сэргээх тохиргоог хийх

Нууц үгээ мартсан эсвэл ямар нэг байдлаар аккаунт руу гаа нэвтрэх боломжгүй болсон бол нууц үг шинээр солихын тулд цахим шуудан илгээдэг олон үйлчилгээ байдаг. Тиймээс сэргээхэд шаардлагатай бүртгэлтэй хаягууд тань идэвхтэй байгаа эсэхийг нягталж байгаарай.

Зарим тохиолдолд сэргээх утасны дугаар бүртгүүлж, текст мессежээр юмуу дуудлагаар нууц дугаараа шинээр солих кодыг авдаг. Энэ нь одоогийн байдлаар хамгийн амар, хялбар аргуудын нэг юм. Утасны дугаараа өгөхийг зөвшөөрөөгүй нөхцөлд олонх нь аюулгүй байдлын асуулт сонгуулан асуудаг. Асуултаа хариултыг нь мартахааргүй боловч давтагдахааргүй байхаар сонгоно. Хариултаа мөн дээр дурдсан аргаар бүтээж болох ба энэ нь хэн нэгэн хариултыг нь мэддэг байсан ч хэрхэн бичиж оруулахыг мэдэхгүй байх давуу талтай юм.